



БУЛГАН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Булган аймгийн Хутаг-Өндөр сумын Засаг даргын 2025 оны санхүүгийн
нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн
аудитын хураангуй тайлан

Аудитын код: БУА-2026/9/НА-СТА-ТТЗ

<p>Цахим хуудас: www.open.audit.mn</p> <p>Булган аймаг 2026 он</p>	<p>Булган аймаг дахь төрийн аудитын газрын дарга бөгөөд Тэргүүлэх аудитор: Д.Батцогт Утас:7034-2580 Цахим хаяг: Bulgan@audit.gov.mn</p> <p>Аудитын менежер: Ж.Энхцоодол Утас:9905-7478 Цахим хаяг: enkhtsoodolj@audit.gov.mn</p> <p>Аудитор: Г.Цэрэнлхам Утас:9907-9641 Цахим хаяг: Tserenlkhambg@audit.gov.mn</p>
---	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



**БУЛГАН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Анхдагчдын өргөн чөлөө 1-120,
Жаргалант, 5-р баг, Булган сум, Булган аймаг,
63082, Утас/Факс:7034-2580
Цахим шуудан:bulgan@audit.gov.mn

2026.03.27 № 366

танай _____ ны № _____ т

ХУТАГ-ӨНДӨР СУМЫН ЗАСАГ
ДАРГА Ж.УУГАНБАЯР ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-д заасны дагуу Хутаг-Өндөр сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Хутаг-Өндөр сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

2025 оны төсвийн жилд улсын төсвийн орлогын бүрдүүлэлтээс шалтгаалсан төсвийн зарлагын хязгаарлалт хийгдсэн "Төсвийн сахилга бат, хариуцлагыг чангатгах тухай" Монгол Улсын Ерөнхий сайдын 2025 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн 05 дугаар албан даалгаврын хэрэгжилтийг хангаж ажилласан байна.

Сумын ИТХ-ын 2025 оны 22 дугаар тогтоолоор сумын Засаг даргын үйл ажиллагааны "Хутаг-Өндөрийн сэргэлт" хөтөлбөрийн биелэлтийг 81.4 хувьтай "Үр дүн хүлээгдэж байгаа" гэж үнэлүүлсэн байна.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

6326050585

Сумын ИТХ-ын хуралдаанаар 2025 оны төсөвт Орон нутгийн хөгжлийн сангаас 1,024.3 сая төгрөг, Байгаль хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний зардлаас 230.7 сая төгрөгийг батлуулж, хэрэгжилтийг хангаж ажилласан байна.

Бусад асуудлын хэсэг

Нийгмийн халамж, цалин хөлстэй холбоотой 2025 онд төрийн албан хаагчийн цалин, тэтгэврийн хэмжээг 6 хувиар нэмэгдүүлсэн, "Эхийн алдар" одонтой эхийн мөнгөн тэтгэмжийг хоёр дахин нэмэгдүүлсэн, хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 20 хувиар нэмэгдүүлж, 792 мянган төгрөг болгосон, ахмад настны тухай хуульд ахмад настан хөдөлмөрийн гэрээгээр ажиллах тохиолдолд тэтгэврийн даатгалын төрөлд даатгуулахгүй байж болох хууль, эрх зүйн өөрчлөлт мөрдөгдөж эхэлсэн байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Д.БАТЦОГТ

Хоёр. Санхүүгийн ба төсвийн гүйцэтгэлийн тайлангийн гол үзүүлэлтүүд

(мянган төгрөгөөр)

Үзүүлэлт	2024.12.31	2025.12.31
Санхүүгийн байдлын тайлан		
Эргэлтийн хөрөнгийн дүн	1,141,296.1	930,134.7
Эргэлтийн бус хөрөнгийн дүн	7,686,295.6	8,894,938.9
Нийт хөрөнгийн дүн	8,827,591.7	9,825,073.6
Нийт өр төлбөрийн дүн	110,367.1	152,998.8
Цэвэр хөрөнгө/өмчийн дүн	8,717,224.7	9,672,074.9
Өр төлбөр, цэвэр хөрөнгө/өмчийн дүн	8,827,591.7	9,825,073.6
Санхүүгийн үр дүнгийн тайлан		
Үйл ажиллагааны орлогын дүн	5,569,826.3	5,601,708.4
Үйл ажиллагааны зардлын дүн	4,464,825.2	4,627,443.7
Үйл ажиллагааны үр дүн	1,105,001.1	974,264.7
Үйл ажиллагааны бус зардал	(128.3)	(25,369.1)
Үйл ажиллагааны нийт үр дүн	1,104,872.8	948,895.6
Цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан		
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	7,612,351.9	8,723,179.3
Тайлант оны үр дүн	1,104,872.8	948,895.6
Эцсийн үлдэгдэл	8,717,224.7	9,672,074.9
Мөнгөн гүйлгээний тайлан		
Үйл ажиллагааны мөнгөн орлогын дүн	4,719,093.4	4,246,351.2
Үйл ажиллагааны мөнгөн зарлагын дүн	3,412,750.3	3,554,197.3
Үйл ажиллагааны ЦМГ	1,306,343.1	692,153.9
Хөрөнгө оруулалтын ЦМГ	(930,950.0)	(903,102.0)
Санхүүгийн ажиллагааны ЦМГ	(250.0)	(122,093.2)
Нийт цэвэр мөнгөн гүйлгээ	375,143.1	(333,041.3)
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	331,350.0	706,493.2
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	706,493.1	373,451.9
Төсвийн гүйцэтгэлийн тайлан		
Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн	3,368,720.3	3,554,538.8
Урсгал зардал	2,720,293.0	2,717,037.4
Хөрөнгийн зардал	788,988.9	837,501.3
Зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр	3,368,720.3	3,554,538.8
Орон нутгийн төсвөөс	2,517,555.4	2,505,239.0
ОНХНС-ийн шилжүүлсэн орлого	601,786.8	509,342.4
Төсөвт байгууллагын үйл ажиллагаанаас	108,816.3	126,204.8
Урьд оны эхний үлдэгдлээс	140561.7	413,752.6

Хутаг-Өндөр сум нь тэргүүлэх чиглэлээ “Сумынхаа эдийн засаг, нийгмийн хөгжлийг хангах стратегийг төлөвлөх, оновчтой бодлого боловсруулах, тэдгээрийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, бодлогын хэрэгжилтийн явц байдалд хяналт шинжилгээ хийх, үр дүнг үнэлж дүгнэх, төрийн албан хаагчдыг мэргэжлийн удирдлагаар хангах, төрийн албаны стандартыг хангуулах, иргэдэд захиргааны үйлчилгээ үзүүлэх замаар сумын хөгжилд хувь нэмэр оруулах үүргийг сумын Засаг даргын Тамгын газар хүлээнэ” хэмээн тодорхойлон ажиллажээ.

Сумын Засаг дарга хуульд заасан дараах чиг үүргийг хэрэгжүүлж ажилласан байна. Үүнд:

- Сумын хөгжлийн үндсэн чиглэл, бодлого, төлөвлөлт;
- Сумын өмчийн ашиглалт, эзэмшилт, захиран зарцуулалт, түүнд тавих хяналт
- Сумын төсөв, түүний төлөвлөлт, гүйцэтгэл, тайлан, хяналт;
- Хууль тогтоомжид заасан хүрээнд албан татвар, төлбөр хураамжийн хувь хэмжээг тогтоох асуудал;
- Сумын орон нутгийн хөгжлийн сангийн төлөвлөлт, хуваарилалт болон бусад сангийн бүрдүүлэлт, зарцуулалт, тайлан, хяналт;
- Аймгийн хүний нөөцийн хөтөлбөрийн хэрэгжилт, ажиллах нөхцөл;
- Аймгийн хүнс, хөдөө аж ахуй, үйлдвэрлэлийн хөтөлбөрийн хэрэгжилт;
- Сумын хүн амын ундны болон ахуйн хэрэгцээний уст цэгийн төлөвлөлт, байршил, ашиглалт, хамгаалалт;
- Худалдаа, үйлчилгээний зохион байгуулалт, хяналт;
- Орон сууц, нийтийн аж ахуйн удирдлага;
- Суурин газрын замын хөдөлгөөн, авто зогсоолын зохицуулалт;
- Хөшөө дурсгалын байршил, хамгаалалт;
- Нийтийн эзэмшлийн зам, талбай, олон нийтийн соёл амралтын хүрээлэн, ногоон байгууламжийн ашиглалт, хамгаалалт;
- Аялал жуулчлалын үйл ажиллагааны зохицуулалт;
- Хог хаягдлын цэгийн байршил, энгийн хог хаягдлын менежмент;
- Оршуулгын газрын үйл ажиллагааны зохицуулалт;
- Сумын сургууль, цэцэрлэг, эмнэлэг, соёлын төв, номын сан, биеийн тамир, спортын барилга байгууламж, хөдлөх хөрөнгийн ашиглалт, засвар;
- Гал түймэр, үерийн хамгаалалтын байгууламж, суваг шуудуу, арчлалт;
- Орон нутгийн цэвэрлэх байгууламжийн арчлалт;
- Орон нутгийн зам, гүүр, тэмдэг, тэмдэглэгээ, арчлалт, хамгаалалт;
- Суурин газрын гэрэлтүүлэг, арчлалт;
- Бэлчээрийн ашиглалт, хамгаалалт;

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа болон санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг дараах хууль тогтоомж, эрх зүйн актуудад өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Төсвийн тухай хууль;
- Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хууль;
- Аж ахуй нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль;
- Малчны тухай хууль;
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль;

- Үндэсний баялгийн сангийн тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуульд нэмэлт оруулах тухай хууль;
- Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай хууль;
- Ахмад настны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль;
- Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хууль;
- Мэдээллийн технологийн үйлдвэрлэлийг дэмжих тухай хууль;
- Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хууль;
- Сангийн сайдын 2025 оны 01 дүгээр сарын 03-ны өдрийн А/03 дугаар тушаалаар “Төсвийн байгууллагын дагаж мөрдөх, нягтлан бодох бүртгэлийн журам”;
- Сангийн сайдын 2025 оны 02 дугаар сарын 06-ны өдрийн А/25 дугаар тушаалаар “Аж ахуйн нэгж, байгууллагын ангилал, шалгуур үзүүлэлтийг тогтоох журам”;
- Засгийн газрын агентлагийн бүтэц, орон тооны талаар хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай 2025 оны 52 дугаар тогтоол;
- Аймгийн ЗДТГ-ын бүтэц, орон тооны хязгаарыг шинэчлэн тогтоох тухай 2025 оны 37 дугаар тогтоол;
- МУ-ын Ерөнхий сайдын 2025 оны 05 дугаар албан даалгавар;

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөгүй байна гэж үзлээ.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

Засаг даргын үйл ажиллагааны “Хутаг-Өндөрийн сэргэлт” мөрийн хөтөлбөрийг сумын ИТХ-ын 2025 оны 22 дугаар тогтоолоор 81.4 хувьтай “Үр дүн хүлээгдэж байгаа” гэж үнэлсэн байна.

Дөрөв. Асуудлын онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 01 дүгээр сарын 14-ний өдрийн хуралдааны 3 дугаар тэмдэглэлээр Хойд бүсийн зөвлөлийн анхдугаар хуралдаан, Хойд бүсийн хөгжлийн чуулган, Засгийн газрын өргөтгөсөн хуралдааныг Булган аймагт зохион байгуулсан.

Нийгмийн халамж, цалин хөлстэй холбоотой 2025 онд төрийн албан хаагчийн цалин, тэтгэврийн хэмжээг 6 хувиар нэмэгдүүлсэн, “Эхийн алдар” одонтой эхийн мөнгөн тэтгэмжийг хоёр дахин нэмэгдүүлсэн, хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 20 хувиар нэмэгдүүлж, 792.0 мянган төгрөг болгосон, ахмад настны тухай хуульд ахмад настан хөдөлмөрийн гэрээгээр ажиллах тохиолдолд тэтгэврийн даатгалын төрөлд даатгуулахгүй байж болох хууль, эрх зүйн өөрчлөлт мөрдөгдөж эхэлсэн байна.

Тав. Аудитын гол асуудал

Хутаг-Өндөр сумын Засаг даргын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд 1 төсвийн байгууллага дүгнэлттэй, 1 төсвийн байгууллага, 4 орон нутгийн тусгай сангийн санхүүгийн тайлан түүвэрт хамрагдсан.

Улсын төсвийн байгууллагуудад орон нутгийн төсвөөс олгосон байр ашиглалтын зардлын санхүүжилт, гүйцэтгэл төсвийн гүйцэтгэлийн тайланд нэгтгэгдсэн байна.

Хутаг-Өндөр сумын Засаг даргын харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд нийт 54.4 сая төгрөгийн 3 алдаа илэрснээс аудитын явцад алдааг санхүүгийн тайланд залруулсан байна.

Хутаг-Өндөр сумын Засаг даргын харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд нийт 1,957.4 сая төгрөгийн 10 зөрчил илэрснээс, 0.2 сая төгрөгийн зөрчилд 1 төлбөрийн акт, 1,941.9 сая төгрөгийн зөрчилд 3 албан шаардлага, 15.3 сая төгрөгийн 5 зөрчилд зөвлөмж, 1 албан тушаалтанд хариуцлага тооцуулах албан шаардлагыг хүргүүлсэн байна.

Зургаа. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна. Нийцлийн асуудлаар илэрсэн 2 зөрчилд зөвлөмж өглөө.

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд мэдээлбэл зохих 145 мэдээллээс төсвийн гүйцэтгэлийн 6, бусад хэсгийн 1 нийт 7 мэдээлэл хугацаа хоцроож мэдээлсэн байна.

Шийдвэрлэсэн нь: Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй гэж дүгнэн Төсвийн төвлөрүүлэн захирагчийн мэдээлбэл зохих мэдээллийг хугацаанд нь бүрэн мэдээлж хэвших зөвлөмж хүргүүллээ.

Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Завсрын аудитын талаар

Завсрын аудитад шалгагдагч байгууллагын 2025 оны 2 дугаар улирлын санхүүгийн тайланг хамруулж, урсгал зардал, нэмэлт санхүүжилтийн данснуудын хувьд горим, сорил хэрэгжүүлж, аудитын төлөвлөгөөг боловсруулан батлуулж ажиллалаа.

Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх аудитаар өгсөн төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилтийн биелэлтийг FAS.audit.mn системээр ирүүлсэн байна.

Хүснэгт 13. Аудитын шийдвэрийн хэрэгжилт (сая төгрөгөөр)

Үзүүлэлт	Өмнөх аудитаар		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Албан шаардлага	3	3,616.8	3	3,616.8	100.0
Зөвлөмж	3	19.9	3	19.9	100.0
Нийт дүн	6	3,636.7	6	3,636.7	100.0

Эх сурвалж: Fas.audit.mn цахим системээр ирүүлсэн шийдвэрийн хэрэгжилтийн тайлан.

Долоо. Дараагийн аудитаар анхаарах асуудал

1. Төсвийн төвлөрүүлэн захирагч нь тайлант онд хэрэгжүүлэх хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн талаарх чанарын болон тоо хэмжээний үзүүлэлтийн хэрэгжилт, үр дүнг тайлагнаагүй байна. Тайлант оны төсвийг зарцуулснаар хэрэгжүүлсэн төсөл, хөтөлбөр, хүрсэн үр дүнг хянаж үзэх;
2. “Илчит хутаг” ОНӨХХК нь 2025 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудитаар 139.0 сая төгрөгийн ашигтай ажилласан нь ОНХС-аас 160.0 сая төгрөгийн хөрөнгийг үнэ төлбөргүй шилжүүлэн авснаас нөлөөлсөн байна. Зорилтот түвшин, үр ашгийн тооцоог ТУЗ-өөр батлуулж ажиллах, орон нутгийн өмчит хуулийн этгээдийн засаглал, ашиг ажиллагааны талаар анхаарч үзэх;
3. Үндсэн хөрөнгийн ашиглалт, хадгалалт, хамгаалалттай холбоотой зөрчил ихээр илэрсэн тул орон нутгийн өмчийн ашиглалт, өмчлөл бүртгэлийн талаар дараагийн аудитаар тус тус анхаарч үзэх нь зүйтэй гэж үзлээ.

Найм. НЭГТГЭСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНД ХИЙСЭН АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар 100.9 сая төгрөгийн 5 алдаа, зөрчил илэрсэнд 15.4 сая төгрөгийн 1 алдааг залруулж, 85.5 сая төгрөгийн зөрчилд 3 зөвлөмж өглөө.

Хутаг-Өндөр сумын Засаг даргын 2025 оны нэгтгэсэн санхүүгийн тайланд аудит хийх явцад дараах залруулгыг хийлээ. Үүнд:

- Илчит хутаг” ОНӨХХК-ий орлогын албан татварын зардлыг нэгтгэсэн санхүүгийн үр дүнгийн тайланд тайлагнаагүйг залруулсан;

Нийт илрүүлсэн алдаа, зөрчлөөс залруулагдаагүй 85.5 сая төгрөгийн зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс 2.3 сая төгрөгөөр дутуу тул “Өөрчлөлтгүй” дүгнэлт өглөө.

5.1 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Төсвийн төлөвлөлттэй холбоотой асуудал

1.1 Илрүүлэлт: Сумын ИТХ-д 2025 оны өргөн мэдүүлсэн төсвийн төсөлд худалдан авах ажиллагааны төлөвлөгөөний төсөл байхгүй. Энэ нь Сангийн сайдын 2012 оны 244 дүгээр тушаалын баталсан "Орон нутгийн төсөл боловсруулах журам"-ын 7.1.5 дахь заалт, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Сумын ИТХ-д дараа оны төсвийн төслийг өргөн мэдүүлэхдээ хуульд, журамд заасан шаардлагыг бүрэн хангуулж ажиллах.

2. Орлогын данстай холбоотой асуудал

2.1 Илрүүлэлт: Цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлого, үйл ажиллагааны орлого, Малын тоо толгойн албан татвар, Байгалийн нөөц ашигласны төлбөр, Ойн нөөц ашигласны төлбөр болон Ус рашааны нөөц ашигласны төлбөрийн орлого давж биелж, бусад татварын орлогыг бүрэн төвлөрүүлээгүй, орлогын төлөвлөгөөний биелэлт хангалтгүй байна.

Өгсөн зөвлөмж: Орон нутгийн төсвийн орлогын төлөвлөгөөг биелүүлэхэд нөөц боломжоо дайчлан ажил зохион байгуулж ажиллах.

3.Авлагын данстай холбоотой асуудал

3.1 Илрүүлэлт: Авлагын дансанд улсын төсвийн хөрөнгө оруулалт нэртэй байгууллагад 8.7 сая төгрөгийн үлдэгдэл байна.

Өгсөн зөвлөмж: Төсөвгүй, улсын төсвийн хөрөнгө оруулалтын авлагын үлдэгдлийг бууруулах арга хэмжээг зохион байгуулж ажиллах.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

8.1 Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл:

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

(сая төгрөгөөр)

Байгууллагын нэр	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Илчит хутаг ОНӨХХК-ий орлогын албан татварын зардлыг тайлагнаагүй.	1	15.4	1	15.4	-	-	1	15.4	-	-	-	-

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

(сая төгрөгөөр)

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Бууны албан татвар, ойн нөөц ашигласны төлбөр, малд ногдуулах албан татвар, түгээмэл тархацхог хаягдлын үйлчилгээний хураамж, газрын төлбөрийн орлогыг бүрэн төвлөрүүлээгүй, орлогын төлөвлөгөөний биелэлт хангалтгүй.	1	76.8					1	76.8				
Сумын ИТХ-д дараа оны төсвийн төслийг өргөн	1	-					1	-				

барихдаа хуульд, журамд заасан шаардлагыг бүрэн хангуулж ажиллах.												
Улсын төсвийн хөрөнгө оруулалтын данс бүртгэлтэй.	1	-					1	-				
Дүн	3	76.8					3	76.8				

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

(сая төгрөгөөр)

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс						
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил									
шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд мэдээлбэл зохих 145 мэдээллээс 3 мэдээлэл хугацаа хоцроож мэдээлсэн.	1	-						1	-
Дүн	1	-	-	-	-	-	-	1	-